



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ**

2021 оны 11 сарын 24 өдөр

Дугаар 123

Мандалговь

**Хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай**


Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 30 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 1 дүгээр зүйлийн 1.2 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг: Аймгийн Биеийн тамир, спортын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 9,856,063.26 /есөн сая найман зуун тавин зургаан мянга жаран гурван төгрөг хорин зургаан мөнгө/ төгрөгийн балансын үнэтэй, 1,675,858.57 /нэг сая зургаан зуун далан таван мянга найман зуун тавин найман төгрөг тавин долоон мөнгө/ төгрөгийн үлдэгдэл өртөгтэй 20 нэр төрлийн 28 ширхэг хавсралтад дурдсан хөрөнгийг акталж данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

Хоёр: Биеийн тамир, спортын газрын дарга (А.Отгонбаатар)-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

- 2.1 Эд хөрөнгийг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор акталж устган данснаас хассаны дараа холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах,
- 2.2 Энэ тогтоолын биелэлтийг 2021 оны 4 дүгээр улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

Гурав: Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА  С.ОД-ЭРДЭНЭ



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2021 оны 11 дүгээр сарын
24-ний өдрийн 123 дугаар тогтоолын хавсралт

Биеийн тамир спортын газрын акллах хөрөнгийн мэдээлэл

Д/Д	Хөрөнгийн нэр	Ашиглалтанд орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Данснаас хасах болсон шалтгаан	Акллах төрөл 1. Устгах 2. Худалдаа 3. Сэлбэг
1	Компьютер-2018	12/26/2008	ш	1	761800	761800	761800	0	Эвдэрсэн	Устгах
2	Компьютер-2013	6/30/2013	ш	2	550000	1100000	1100000	0	Эвдэрсэн	Устгах
3	Афуртур-39205	11/29/2013	ш	1	628543.29	628543.29	628543.29	0	Эвдэрсэн	Устгах
4	Гагнуурын аппарат	12/28/2009	ш	1	150000	150000	150000	0	Эвдэрсэн	Устгах
5	ЭД 98Н22В сандал	12/31/2018	ш	3	10000	30000	30000	0	Эвдэрсэн	Устгах
6	ЭД 9898 давцан	12/31/2018	ш	2	25000	50000	45833.04	4166.96	Эвдэрсэн	Устгах
7	ЭД Бехийн дэвжээ	12/31/2018	ш	1	250000	250000	250000	0	Эвдэрсэн	Устгах
8	ЭД шүүгээ	12/31/2018	ш	1	30000	30000	30000	0	Эвдэрсэн	Устгах
9	Дрож ЭД	12/31/2018	ш	1	25000	25000	25000	0	Эвдэрсэн	Устгах
10	Шкаф модон	6/30/2012	ш	1	220000	220000	220000	0	Эвдэрсэн	Устгах
11	Ширээ	6/30/2018	ш	1	10000	10000	10000	0	Эвдэрсэн	Устгах
12	Сагсны самбар	12/31/2009	Хос	1	1320000	1320000	1320000	0	Эвдэрсэн	Устгах
13	Эрдэнэт хивс	12/28/2012	ш	1	350000	350000	350000	0	Эвдэрсэн	Устгах
14	Зөвлөгөөны ширээ	1/1/2002	ш	1	166219.97	166219.97	166219.97	0	Эвдэрсэн	Устгах
15	Чадлын өсгөгч дууны пульта	12/31/2020	ш	1	1000000	1000000	375000.03	624999.97	Эвдэрсэн	Устгах
16	Тоглуулагч-39205	1/14/2020	ш	1	494000	494000	432249.93	61750.07	Эвдэрсэн	Устгах
17	Чанга яригч-39205	1/14/2020	ш	2	693000	1386000	1212750	173250	Эвдэрсэн	Устгах
18	НӨТЕ БҮҮК-2016	1/14/2020	ш	1	1300000	1300000	758,333.31	541,666.69	Эвдэрсэн	Устгах

19	ЭД Өндөр жин хэмжигч	12/25/2018	ш	1	544500	544500	299,475.00	245,025.00	Эвдэрсэн	Устгах
20	ЭД Ург сандал	12/31/2020	ш	4	10000	40000	15000.12	24999.88	Эвдэрсэн	Устгах
	Нийт			28	8538063.26	9856063.26	8180204.69	1675858.57		